



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар СХШ-2025/22

Сүхбаатар сум

Хүдэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
ажлын албаны Санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны дугаар 11 сарын 01-ны өдрийн №СХШ-2025/15/-ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Хүдэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүү хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Хүдэр сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны (цаашид Хүдэр сумын ИТХ гэх)-ын 2024, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Хүдэр сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3738639 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131354001 дугаартай, 100131354401 дугаартай нэмэлт дансыг ашиглаж байна.

1.5. Хүдэр сумын ИТХ-ын төсвийн орлого, тайлан, төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Цэцэгсайхан, 2-р гарын үсгийг нягтлан бодогч П.Гантуяа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.6. Хүдэр сумын ИТХ нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 2 нийт 3 албан хаагч үйл ажиллагаа явуулж байна.

4395831167

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувь, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2024 онд 93.1 хувь, сумын ИТХ-ын даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2024 онд 92.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 онд орон нутгийн төсвөөс 252,485.6 мянган төгрөгөөр 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 307,901.90 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 2024 онд 227,816.2 мянган төгрөгийг буюу 90 хувийг , 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 244,049.27 мянган төгрөгийг буюу 80 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

Үзүүлэлт	2024 он			2025 он		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	252,485.60	227,816.26	24,669.34	307,901.90	244,049.27	63,852.63
УРСГАЛ ЗАРДАЛ	252,485.60	227,816.26	24,669.34	307,901.90	244,049.27	63,852.63
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,103.60	218,311.28	23,792.32	293,119.50	230,579.27	62,540.23
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,941.90	147,102.38	10,839.52	168,137.00	143,538.70	24,598.30
Үндсэн цалин	98,685.30	88,459.71	10,225.59	65,024.60	64,337.58	687.02
Нэмэгдэл	43,905.80	52,993.24	(9,087.44)	84,350.60	71,469.12	12,881.48
Урамшуулал	15,350.80	5,649.43	9,701.37	18,761.80	7,732.00	11,029.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,742.80	17,804.45	1,938.35	21,050.90	18,129.15	2,921.75
Тэтгэврийн даатгал	13,425.10	12,527.34	897.76	14,291.70	12,282.98	2,008.72
Тэтгэмжийн даатгал	1,579.50	1,349.23	230.27	1,681.40	1,454.29	227.11

ҮОМШӨ-ний даатгал	789.70	660.18	129.52	870.90	726.83	144.07
Ажилгүйдлийн даатгал	789.70	650.24	139.46	810.40	724.40	86.00
Эрүүл мэндийн даатгал	3,158.80	2,617.46	541.34	3,396.50	2,940.65	455.85
Хангамж, бараа материалын зардал	11,150.90	7,641.62	3,509.28	13,169.40	8,888.08	4,281.33
Бичиг хэрэг	1,000.00	1,000.00	-	1,093.80	796.10	297.70
Тээвэр, шатахуун	9,173.80	6,109.24	3,064.56	10,236.80	6,880.00	3,356.80
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400.00	36.63	363.37	670.30	17.88	652.43
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	577.10	495.75	81.35	1,168.50	1,194.10	(25.60)
Нормативт зардал	58.80	-	58.80	-	-	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	58.80	-	58.80	-	-	-
Эд хогшил, урсгал засварын зардал	1,731.20	1,399.97	331.23	25,320.40	25,142.00	178.40
Багаж, техник, хэрэгсэл	1,731.20	1,399.97	331.23	23,629.40	23,451.00	178.40
Тавилга	-	-	-	1,691.00	1,691.00	-
Томилолт, зочны зардал	1,635.00	1,635.00	-	2,224.10	1,617.80	606.30
Дотоод албан томилолт	1,635.00	1,635.00	-	2,224.10	1,617.80	606.30
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,272.90	10,644.45	4,628.45	17,447.10	5,686.00	11,761.10
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,088.20	10,644.45	4,443.75	17,256.20	5,686.00	11,570.20
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	184.70	-	184.70	190.90	-	190.90
Бараа үйлчилгээний бусад зардал	34,570.10	32,083.41	2,486.69	45,770.60	27,577.55	18,193.05
Бараа үйлчилгээний бусад зардал	32,838.90	31,271.91	1,566.99	40,711.80	27,267.55	13,444.25
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,731.20	811.50	919.70	5,058.80	310.00	4,748.80
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,382.00	9,504.98	877.02	14,782.40	13,470.00	1,312.40
Бусад урсгал шилжүүлэг	10,382.00	9,504.98	877.02	14,782.40	13,470.00	1,312.40
Хөдөө орон нутаг тогтвор суур	9,582.00	8,754.98	827.02			-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800.00	750.00	50.00	14,782.40	13,470.00	1,312.40
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	252,485.60	227,816.26	24,669.34	307,901.90	244,049.27	63,852.63

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2024 онд 157,941.9 мянган төгрөг 2025 онд 168,137.0 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2024 онд 147,102.3 мянган

төгрөгийг зарцуулж 10,839.5 мянган төгрөгийг хэмнэж 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 143,538.7 мянган төгрөгийг зарцуулж 24,598.3 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2. **Хангамж бараа материалын зардал:** 2024 онд хангамж, бараа материалын зардалд 11,150.9 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 1,000.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 6,109.2 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 36.3 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 495.7 мянган төгрөг зарцуулж 3,509.2 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2025 оны 3 улирлын байдлаар хангамж, бараа материалын зардалд 13,169.4 мянган төгрөг батлагдаж 67.4 хувь зарцуулсан нь санхүүжилт дутуу хийгдсэнтэй холбоотой.
3. **Томилолтын зардал:** 2024 онд 1,635.0 мянган төгрөг батлагдаж 100 хувь, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 2,224.1 мянган төгрөг батлагдаж 1,617.8 мянган төгрөг зарцуулж 606.3 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.
4. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2024 онд 15,272.9 мянган төгрөг батлагдсанаас 10,644.4 мянган төгрөг зарцуулж 4,628.4 мянган төгрөг хэмнэсэн, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 17,447.1 мянган төгрөг батлагдсанаас 5,686.0 мянган төгрөгийг зарцуулж 11,761.1 мянган төгрөгийг хэмнэж БГАҮ-ний зардалд тайлагнасан байна.
5. **Бусад зардал:** 2024 онд 34,570.1 мянган төгрөг батлагдаж 32,083.4 мянган төгрөгийг зарцуулж 2,486.6 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 45,770.6 мянган төгрөг батлагдсанаас 27,577.5 мянган төгрөгийг зарцуулж 18,193.0 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.
6. **Урсгал шилжүүлгийн зардал:** 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчийн тэтгэмжид 9,582.0 мянган төгрөг батлагдсанаас 8,754.9 мянган төгрөгийг зарцуулж 827.0 мянган төгрөгийн хэмнэлттэй, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 800.0 мянган төгрөг батлагдаж 750.0 мянган төгрөгийг зарцуулж 50.0 мянган төгрөгийн хэмнэсэн 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчийн тэтгэмжийн зардал батлагдаж гараагүй, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 14,782.4 мянган төгрөг батлагдсанаас 13,470.0 мянган төгрөгийг зарцуулж 1,312.4 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024,2025 онуудад сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

Сумын ИТХ-ын ажлын алба нь 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд батлагдсан төсвийн 2024 онд 157,941.9 мянган төгрөг буюу 62 хувь, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 168,137.0 мянган төгрөг буюу 54 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөсөн байна. 2024 онд 147,102.3 мянган төгрөгийг буюу 58 хувийг, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 143,538.7 мянган төгрөг буюу 47 хувийг цалин хөлс, нэмэгдэл хөлс олгоход зарцуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2025 оны нийт цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардал өмнөх оноос нэмэгдсэн байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгаж үзэхэд илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

2.4 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2025 онд төсвийн хөрөнгөөр "Тоног төхөөрөмж IPAD худалдан авах" ажлыг гүйцэтгэх №СЭ-ХҮДЭР-2025/05 дугаартай гэрээг "ЭЙ энд И инсуранси" ХХК-тай байгуулан 23,000.0 сая төгрөгний санхүүжилтээр 13ш IPAD худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэж ажилласан байна.

2.5. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв санхүү, бүртгэл тайлагналтай холбоотой төлбөрийн акт-1, албан шаардлага-2 хүргэгдсэнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Хүдэр сумын ИТХ-ын ажлын албаны 2024,2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл хөтлөлт, шатахууны норм, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй, зардлын бүлэг хоорон гүйлгэн зарцуулсан зэрэг дараах зөрчил дутагдал илэрлээ.

Илрүүлэлт 1 Тээврийн хэрэгслэлийн 100 км гүйлтэд зарцуулах норм баримтлаагүй жолоочийн тооцооны хуудасны маягтанд явсан заалтыг бичихгүй дутуу бөглөж ажилд гарсан тухай бүрээр нь хөтлүүлээгүй 2024 онд 6,080.0 мянган төгрөгийн шатахуун олгож зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг, Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар

тушаалаар батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралт дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсыг ажилд гарсан тухай бүрд нь километрийн заалтыг бичүүлж шатахууныг сар бүр тооцож тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 650.0 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн нэг удаагийн тэтгэмжийн зардалд зориулалт бусаар зарцуулж гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах нь үндэслэл болно" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарлагыг хууль, эрхийн актад нийцүүлэн үнэн зөв төлөвлөж зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Хүдэр сумын ИТХ-ын 2024, 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд " эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Хүдэр сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 6,730.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 650.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 6,080.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн

гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт даалгав.

БИЧСЭН:


САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

ХҮДЭР СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Д.ЦЭЦЭГСАЙХАН
НЯГТЛАН БОДОГЧ



П.

П.ГАНТУЯА